


ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

Улс төрийн нам

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



Агуулга

	Хуудас
Намын мэдээлэл	2
Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
Санхүүгийн тайлан	5-8
Санхүү байдлын тайлан	5
Орлогын дэлгэрэнгүй тайлан	6
Өмчийн өөрчлөлтийн тайлан	7
Мөнгөн гүйлгээний тайлан	8
Санхүүгийн тайлангийн тэмдэглэл	9-14

“ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ” Улс төрийн нам

Намын мэдээлэл

**Үүсгэн байгуулах
шийдвэр**

“ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ” нь 2022 оны 03 сарын 03-ны өдрийн үүсгэн байгуулагдаж, 2022 оны 05 сарын 20-нд Монгол улсын Дээд шүүхэд бүртгэгдсэн.

**Гэрчилгээ ба тусгай
зөвшөөрөл**

“ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ” нь 2022 оны 05 сарын 20-ны өдөр Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж 8012103216 дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. РД:8489254

Гүйцэтгэх Удирдлага

Ц.Оюунгэрэл
М.Мөнхцэцэг

Дарга
Санхүү эрхэлсэн дарга

Байнгын хаяг

“ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ”
Сүхбаатар дүүрэг, 3-р хороо,
Саруул төв, 107 тоот
Улаанбаатар хот, Монгол Улс

Аудитор

“ЭВИДЕНСЕ АУДИТ” ХХК
Сүхбаатар дүүрэг 9-р хороо Алтайн гудамж,
Хойморь оффис, 502 тоот,
Улаанбаатар хот, Монгол Улс



“ЭВИДЕНСЕ-АУДИТ” ХХК

Аудит, аутсорсинг

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

9-р хороо, 7-р хороолол, Алтайн гудамж 281,

Хоймор оффис, 502 тоот,

Регистр № 5211875,

Утас: 7000-7121

E-mail: info@evidenceaudit.mn

Огноо: 2026 оны 04 сарын 20 № 16 /2026

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Аудиторын дүгнэлт

Бид “ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангуудад аудит хийсэн.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт /АОУС/-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад *Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт тайлбарласан. Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл /НБЁЗОУСЗ/-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу бид үйлчлүүлэгч намаас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ -өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Гол аудитын асуудлууд

Бид мэргэжлийн үнэлгээгээр дараах асуудлыг хамгийн өндөр эрсдэлтэй гэж тодорхойлов:

- Хандивын эх үүсвэрийн тодорхойгүй байдал
- Бэлэн мөнгөний хяналтын сул байдал

Эдгээр асуудлууд нь аудитын явцад хамгийн их анхаарал шаардсан бөгөөд аудитын хамрах хүрээ, нотлох баримтын түвшинд шууд нөлөөлсөн. Эдгээр асуудлууд дээр бид нэмэлт аудитын горим хэрэгжүүлсэн болно.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь намын удирдлагын үүрэг хариуцлага болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүгийн тайлангуудыг заль мэх юмуу алдаанаас үүдэлтэй буруу илэрхийлэлээс ангид бэлтгэж шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг тогтоож ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг намын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бусад хууль, зохицуулалтын шаардлага

Бид аудитын явцад улс төрийн намын санхүүжилт, хандив, зарцуулалт нь Монгол Улсын Улс төрийн намын тухай хууль, тогтоомж болон Нягтлан бодох бүртгэлийн тухай холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгасан.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 38.1-д заасан нам болон сонгуулийн төв байгууллагад зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.



“Эвиденс-Аудит” ХХК
Аудитор С.Бадамгарав
Улаанбаатар хот, Монгол Улс
Тусгай зөвшөөрөл: 090-2010

Огноо: 2026.04.20

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх тасалбар болсон
САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

		(төгрөгөөр)	
Үзүүлэлт	Тод	2025.12.31	2024.12.31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5	333,803	3,338,329
Бараа материал	6	4,322,900	4,255,100
Эргэлтийн хөрөнгийн дүн		<u>4,656,703</u>	<u>7,593,429</u>
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	594,000	660,000
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<u>594,000</u>	<u>660,000</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		<u><u>5,250,703</u></u>	<u><u>8,253,429</u></u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	8	99,999	12,000,000
Богино хугацаат өр төлбөрийн дүн		<u>99,999</u>	<u>12,000,000</u>
Өр төлбөрийн нийт дүн		<u>99,999</u>	<u>12,000,000</u>
Эздийн өмч			
Хуримтлагдсан үр дүн	9	5,150,704	(3,746,571)
Эздийн өмчийн дүн		<u>5,150,704</u>	<u>(3,746,571)</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		<u><u>5,250,703</u></u>	<u><u>8,253,429</u></u>

"ЭВИДЕНС-АУДИТ" ХХК
 5211875

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ
2025 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	Тод	(төгрөгөөр) 2025.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого		
Намын гишүүний татвар		12,242,000
Мөнгөн хандив		2,370,000
Мөнгөн бус хандив		990,000
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	3	15,602,000
Үндсэн үйд ажиллагааны зардал		
Үйл ажиллагааны урсгал зардал		6,704,726
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	4	6,704,726
Хуримтлагдсан үр дүн		8,897,275

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ
2025 оны 12 дугаар сарын 31-нээр өдрөөр тасалбар болсон
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2024.12.31	(3,746,571)	(3,746,571)
Өмчид гарсан өөрчлөлт		-
Тайлант үеийн хуримтлагдсан үр дүн	8,897,275	8,897,275
2025.12.31	5,150,704	5,150,704

ЭВИДЕНС-АУДИТ ХХК
521187

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	(төгрөгөөр) 2025.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн (+)	14,612,000
Намын гишүүний татвар	2,370,000
Иргэний өгсөн мөнгөн хандив	12,242,000
Мөнгөн зарлагын дүн (-)	5,716,526
Ашиглалтын зардалд төлсөн	5,648,726
Хангамжийн зүйл худалдан авахад төлсөн	67,800
	8,895,475
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-
Мөнгөн орлогын дүн (+)	99,999
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	99,999
Мөнгөн зарлагын дүн (-)	12,000,000
Бусад мөнгөн зарлага	12,000,000
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн дүн	(11,900,001)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,004,527)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,338,329
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	333,803

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

“ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ” нь 2022 оны 03 сарын 03-ны өдрийн үүсгэн байгуулагдаж, 2022 оны 05 сарын 20-нд Монгол улсын Дээд шүүхэд бүртгэгдсэн байна. Мөн тус өдөр Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж 8012103216 дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

2. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Хороо (“НББОУСХ”) ноос гаргаж, мөрдүүлсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”) болон НББОУСХ-ны Тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн байна.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол хийх болон нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхтэй холбоотой мэргэжлийн шийдлүүдийг хийхийг шаарддаг.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

3.1 Үндсэн хөрөнгө

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Үндсэн хөрөнгө нь намын үйл ажиллагаанд ашиглагдах, бараа үйлчилгээ үйлдвэрлэх, эсхүл захиргааны зориулалтаар ашиглагдах, нэг тайлант хугацаанаас дээш хугацаанд ашиглагдах биет хөрөнгийг илэрхийлнэ.

Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө худалдан авсан өртгөөр бүртгэнэ. Өртөгт тухайн хөрөнгийг ашиглахад бэлэн болгох хүртэл гарсан бүх шууд зардлууд, тухайлбал худалдан авалтын үнэ, тээвэрлэлтийн зардал, суурилуулалтын зардал болон холбогдох бусад шууд зардлууд багтана.

Дараа үеийн зардал

Дараагийн хэмжилтээр үндсэн хөрөнгийг өртгийн загвар (cost model)-аар бүртгэж, хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан цэвэр дансны дүнгээр тайлагнана.

Элэгдэл

Элэгдлийг өмч, барилга, тоног төхөөрөмжийн ашиглагдах хугацаагаар нь шулуун шугамын аргаар байгуулж орлого үр дүнгийн дэлгэрэнгүй тайланд тусгана.

3.2 Бараа материал

Хангамжийн материал нь намын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах, богино хугацаанд хэрэглэгдэх зориулалттай бараа материалуудыг илэрхийлнэ.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

Үүнд албан хэрэгслийн материал, хэвлэмэл материал, сурталчилгааны хэрэглэгдэхүүн болон бусад ижил төстэй зүйлс багтана.

Өртөгт худалдан авалтын үнэ, тээвэрлэлтийн зардал болон материалтай шууд холбоотой бусад зардлуудыг хамруулна. Хангамжийн материалыг өртгөөр бүртгэж, хэрэглээнд зарцуулах үед зардалд хүлээн зөвшөөрч, тайлант хугацааны эцэст өртөг болон цэвэр хэрэгжих үнэ цэнийн аль бага дүнгээр үнэлнэ.

3.3 Дансны болон бусад авлага

Дансны авлага нь намын үйл ажиллагааны явцад гуравдагч этгээдээс авах ёстой мөнгөн дүнг илэрхийлэх бөгөөд хандивын амлалт, урьдчилж олгосон зардал, бусад авах авлагуудыг хамруулна.

Дансны авлагыг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн гүйлгээ үүсэх үед үүссэн бодит дүнгээр бүртгэнэ. Дансны авлагыг хорогдуулсан өртгөөр хэмжиж, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварын дагуу үнэлнэ.

Бусад авлагыг хорогдуулсан өртгөөр хэмжиж, хүлээгдэж буй зээлийн алдагдлын загварын дагуу үнэлнэ.

3.4 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

Монгол Улсын Улс төрийн намын тухай хуулийн 33.2-д зааснаар болон холбогдох санхүүгийн зохицуулалтуудад:

- Намын орлого, зарцуулалт ил тод байх
- банкны дансаар дамжих
- бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно гэсэн заалттай.

Бэлэн мөнгөөр орж ирсэн хандив, татварын мөнгийг тухай бүрт нь харилцахын дансанд хийх бөгөөд үнэн зөв бүртгэж тайлагнана.

3.5 Дансны өглөг

Нам нь гэрээ, хэлцэлд заасан нөхцөл, эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу үүрэг хүлээсэн үед өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Өр төлбөрийг дараах нөхцөл хангагдсан үед хүлээн зөвшөөрнө:

- Намд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн одоогийн үүрэг (хууль эрх зүйн эсхүл үүсмэл үүрэг) байгаа;
- Уг үүргийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц гадагшлах магадлалтай;
- Үүргийн дүнг найдвартай хэмжих боломжтой.

Өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн үүргийг үүсгэсэн гүйлгээний бодит дүнгээр, өөрөөр хэлбэл хүлээн авсан хөрөнгө, үйлчилгээний шударга үнэ цэнээр хэмжинэ.

Хэрэв өр төлбөрийг барагдуулах хугацаа хойшлогдсон бөгөөд мөнгөн гүйлгээ нь хугацааны хувьд материаллаг нөлөөтэй бол уг өр төлбөрийг ирээдүйн мөнгөн гүйлгээг зохих хүүгийн хувь ашиглан дискаунтчилж тооцсон өнөөгийн үнэ цэнээр илэрхийлнэ.

Дараагийн хэмжилтээр өр төлбөрийг:

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

- гэрээний дагуу төлөх дүнгээр, эсхүл
- дискаунтчилсан өртгийн аргаар (шаардлагатай тохиолдолд)

үнэлж, холбогдох хүүгийн зардлыг тайлант үеийн үр, дүнд хүлээн зөвшөөрнө.

3.6 Хуримтлагдсан үр дүн

Хуримтлагдсан үр дүн нь тайлант болон өмнөх тайлант үеүүдийн үйл ажиллагааны илүүдэл (эсхүл алдагдал)-ын хуримтлалыг илэрхийлнэ.

Тайлант хугацааны цэвэр үр дүнг тайлант үеийн эцэст хуримтлагдсан үр дүнд шилжүүлэн бүртгэдэг бөгөөд ингэснээр хуримтлагдсан үр дүн нь тухайн тайлант хугацааны эцсийн байдлаарх нийт хуримтлагдсан үлдэгдлийг харуулна. Хуримтлагдсан үр дүн нь дараах байдлаар өөрчлөгдөнө:

- Тайлант хугацааны илүүдэл (алдагдал);
- Өмнөх тайлант үеийн алдааны засвар (шаардлагатай тохиолдолд);
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөлөл (хэрэв хэрэглэвэл);
- Бусад иж бүрэн орлогын хуримтлал (хамаарах тохиолдолд).

Улс төрийн нам нь ашгийн төлөө бус шинж чанартай тул “хуримтлагдсан ашиг” гэх нэршлийн оронд “хуримтлагдсан үр дүн” (эсхүл “хуримтлагдсан илүүдэл (алдагдал)”) гэсэн нэршлийг хэрэглэнэ.

Хуримтлагдсан үр дүнг санхүүгийн байдлын тайланд өмчийн бүрэлдэхүүн хэсэгт нэгтгэн харуулах бөгөөд түүний дэлгэрэнгүй хөдөлгөөнийг өмчийн өөрчлөлтийн тайлангаар ил тод мэдээлнэ.

3.7 Орлого хүлээн зөвшөөрөлт

Үндсэн үйл ажиллагааны орлого нь намын үндсэн зорилго, үйл ажиллагаатай холбоотойгоор тайлант хугацаанд бий болсон эдийн засгийн өгөөжийн өсөлтийг илэрхийлнэ. Үүнд хандив, гишүүний татвар, төрөөс олгогдох санхүүжилт болон бусад ижил төстэй орлогууд багтана.

- Орлогыг дараах зарчмын дагуу хүлээн зөвшөөрнө:
- Орлого нь намд эдийн засгийн өгөөж орж ирэх магадлалтай;
- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой;
- Холбогдох гүйлгээ бодитоор үүссэн.

Хандив болон буцалтгүй тусламжийн орлогыг тухайн орлого хүлээн авсан үед, эсхүл хүлээн авах эрх үүссэн үед хүлээн зөвшөөрнө. Хэрэв хандив нь тодорхой нөхцөл, зориулалттай бол уг нөхцөл биелэх хүртэл урьдчилгаа орлого (өр төлбөр) хэлбэрээр бүртгэж, нөхцөл биелсэн үед орлогод шилжүүлнэ.

Гишүүний татварын орлогыг холбогдох хугацаанд нь хуримтлалын зарчмаар хүлээн зөвшөөрнө.

Төрөөс олгогдох санхүүжилтийг холбогдох шаардлага, шалгуур биелсэн үед орлогод хүлээн зөвшөөрөх бөгөөд хэрэв тодорхой зардлыг санхүүжүүлэх зориулалттай бол уг зардал үүсэхтэй уялдуулан системтэйгээр орлогод тусгана. Үндсэн үйл ажиллагааны орлогыг санхүүгийн тайланд ангилж толилуулахдаа тэдгээрийн шинж чанарын дагуу бүлэглэн харуулна.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

Мөнгөн бус хандивыг шударга үнэ цэнээр үнэлж, нөхцөлгүй бол хүлээн авсан үед орлогод, нөхцөлтэй бол нөхцөл биелэх үед орлогод хүлээн зөвшөөрнө.

3.8 Үндсэн үйл ажиллагааны зардал

Үндсэн үйл ажиллагааны зардалд намын үндсэн зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой гарсан зардлуудыг хамруулна. Үүнд намын өдөр тутмын үйл ажиллагаа, бодлого хэрэгжилт, зохион байгуулалт, олон нийттэй харилцах үйл ажиллагаатай холбоотой зардлууд багтана.

Зардлыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит гүйлгээний дүнгээр хэмжиж, дараагийн хэмжилтэд нэмэлт үнэлгээ хийхгүйгээр тухайн тайлант хугацаанд бүртгэнэ. Хэрэв урьдчилж төлсөн зардал үүссэн бол түүнийг холбогдох хугацаанд системтэйгээр хуваарилан зардалд хүлээн зөвшөөрнө. Үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүгийн тайланд ангилж толилуулахдаа тэдгээрийн шинж чанарын дагуу бүлэглэн харуулна.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

4. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Үзүүлэлт

2025.12.31

Намын гишүүний татвар	
Мөнгөн хандив	2,370,000
Мөнгөн бус хандив	12,242,000
Борлуулалтын орлогын дүн	990,000
	15,602,000

Намын үндсэн үйл ажиллагааны орлого нь намын гишүүний татвар, мөнгөн хандив, мөнгөн бус хандиваас бүрдсэн бөгөөд тайлант онд төрөөс санхүүжилт аваагүй байна. Намын нийт идэвхтэй гишүүд 76 бөгөөд тухайн тайлант үед 4 гишүүн хувийн шалтгаанаар гарсан гишүүдийн татварын давхардлыг тус тус шалган баталгаажуулсан болно. Мөнгөн хандив нь нийт 16 хүн олгосон бөгөөд хандивлагч тус бүрээр нь Улс төрийн намын тухай хуулийн 33.6 заалтын дээд хэмжээг мөрдсөн эсэхийг тулган баталгаажуулсан. Мөнгөн бус хандив нь тухайн намын веб хөгжүүлэх хандив болохыг тус тус баталгаажуулав.

5. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

Үзүүлэлт

2025.12.31

Хүлээн авалт	1,748,000
Бичиг хэргийн зардал	254,550
Үйлчилгээний зардал	1,064,000
Элэгдлийн зардал	66,000
Зар сурталчилгаа	990,000
Шуудан холбооны зардал	2,413,681
БҮТЭЭ	152,395
Банкны шимтгэлийн зардал	16,100
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	6,704,726

Нийт зардалд гарсан дүн дансны хуулга болон журналын бичилттэй тулгасан бөгөөд зарцуулалт тус бүр ангилал зөв анхан шатны баримтыг баталгаажуулав.

6. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Үзүүлэлт

2025.12.31

2024.12.31

Касст байгаа төгрөг	85,637	85,637
Бэлэн мөнгөний үлдэгдэл	85,637	85,637
<i>Банкин дах төгрөгийн харилцах данс</i>		
Банкинд байгаа төгрөг	223,869	3,228,396
Банкинд байгаа төгрөг сонгуулийн	24,296	24,296
Банкин дах харилцах дансдын үлдэгдэл	248,166	3,252,692
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	333,803	3,338,329

Кассын мөнгөн хөрөнгө нь өглөгийн зориулалттайгаар бэлэн мөнгө хэлбэрээр байгааг баталгаажуулсан болно. Банкин дахь хөрөнгийн үлдэгдлийг гуравдагч этгээдийн баталгаажуулалтаар баталгаажуулав.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМ

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТЭМДЭГЛЭЛ

7. БАРАА МАТЕРИАЛ

Үзүүлэлт	2025.12.31	2024.12.31
Хангамжийн материал	4,322,900	4,255,100
Бараа материалын дүн	4,322,900	4,255,100

Бараа материал нь тамга, бичиг хэрэг, оффис хэрэглээний хангамжийн материалаас бүрдсэн байсан.

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	2025.12.31	2024.12.31
Тавилга эд хогшил	660,000	660,000
Үндсэн хөрөнгийн дүн	660,000	660,000

Хуримтлагдсан элэгдэл

Үзүүлэлт	2025.12.31	2024.12.31
Тавилга эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	66,000	-
Хуримтлагдсан элэгдлийн дүн	66,000	-

Үлдэх өртөг

594,000

660,000

Үндсэн хөрөнгийн дүнд буйдан 1 ширхэг байсан бөгөөд уг хөрөнгийг тайлант үеийн хугацаанд 10 жилийн элэгдлийн шулуун шугамын аргаар тооцож зөв ангилж бүртгэснийг тулгасан.

9. ДАНСНЫ ӨГЛӨГ

Үзүүлэлт	2025.12.31	2024.12.31
Хувь хүнд өгөх өглөг	99,999	12,000,000
Нийт төлбөрийн дүн	99,999	12,000,000

Дансны өглөгийн ангилал, тайлагнал болон уг өглөгийн мөн анхан шатны баримттай тулган баталгаажуулалт хийсэн болно.

10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Санхүүгийн тайлан бэлтгэсэн өдөр болон аудитын тайлангийн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй байна.